

**“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ӨӨРИЙН
ӨМЧЛӨЛИЙН ЦАЙНЫ ГАЗРЫН 72,4 м2 ТАЛБАЙГ ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТҮРЭЭСЛЭХ ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

1. Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга.

Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах “ДЦС-2” ТӨХК-ийн ажилтны цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулах.

2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл:

2.1 Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цагаас өмнө.
2.2 Материал хүлээн авах хаяг	УБ хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, “ДЦС-2” ТӨХК-ийн өөрийн байр, 109 тоот
2.3 Материал нээх хугацаа, хаяг байршил	УБ хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, “ДЦС-2” ТӨХК-ийн өөрийн байр, 109 тоот өрөөнд. /Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний өрөө/
2.4 Эд хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ	Түрээслэх доод үнэ: Эд хөрөнгө түрээслүүлэх 1м.кв талбайн түрээсийн жишиг доод үнэ /м.кв/ - 10.000 төгрөг 1 м.кв-ыг түрээслэх доод үнээс бага үнийн санал ирүүлсэн оролцогчийн материалыг үнэлгээнээс хасч тооцно.
2.5 Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл, бусад мэдээлэл	1. Нийтийн хоолны чиглэлийн үйл ажиллагааг эрхлэж байсныг тодорхойлох гэрээ болон бичиг баримтууд. 2. Одоо ажиллаж байгаа бол тус газрын хаяг, мэдээллийг тодорхой ирүүлэх 3. Үндсэн ажилтны тоо 5–аас доошгүй байх. 2-3 мэргэжлийн тогоочтой байх.
2.6 Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	Тус Компанийн цайны газрыг Даваа-Баасан гараг хүртэл бүтэн цагаар, Бямба гарагт ээлжийн ажилтнуудад хагас цагаар ажиллаж, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнсээр хангаж ажиллах
	• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэн бол иргэний үнэмлэх/ • Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаар мэдээлэл /өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаар/ • Хаана хэрхэн хоолны газар ажиллуулж байсан талаар мэдээлэл, Фото зураг • Санхүүгийн чадварыг нотлох баримт бичиг харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, ажиллагчдын бичиг баримт, тогооч,

2.7 Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	зөөгч гэх мэт /Ажиллах бүрэлдэхүүн 5-аас доошгүй байх/ • Өөрсдийн нөөцөд байх тоног төхөөрөмжийн жагсаалт, зургийн хамт • Үндсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажиллагсад нь эрүүл мэндийн шинжилгээний дэвтэртэй байх, шинжилгээнд бүрэн хамрагдсаныг нотлох баримт бичиг • Нийтийн хоолны чиглэлийн хоолны орц нормын хэмжээ технологийн карт, баримт бичиг ирүүлэх • Үйлчилгээнд гаргах хоолны нэр төрөл, үнийн танилцуулга ирүүлэх, бодитой тодорхой байх
2.8 Нэмэлт мэдээлэл	• Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлж, битүүмжлэн ирүүлнэ. • Оролцогч нь баримт бичгийг бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг хариуцах бөгөөд нээлтэд төлөөллийг оролцуулж болно. • Талбайн дулааны төлбөрөөс бүрэн чөлөөлнө. • Бусад урсгал зардал, тоног төхөөрөмжийн түрээсийг гэрээний заалтаар тохиролцоно • Үндсэн хоолны үнэ нэгдүгээр хоол 9,000 төгрөг, хоёрдугаар хоол 10,000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар тооцож хоолны үнийн саналыг ирүүлнэ. • Захиалгын болон ширхэгийн хоолны меню, үнийг хязгаарлахгүй. • Даваа-Баасан гарагуудад цайны цаг 11:30-12:30 байна. • Бямба гарагт хагас ажлын цагаар ажиллана. Ням гарагт амарна.

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслэх хөрөнгийг өмч эзэмшигч “ДЦС-2” ТӨХК-ийн байран дээр ирж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтыг заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг 70775169/дотуур холбоо 237/, 88003801 утсаар болон www.tpp2.mn цахим хуудаснаас авна уу.

Хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, “ДЦС-2” ТӨХК-ийн өөрийн байр, 109 тоот

Холбогдох албан тушаалтан: Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Даваадорж

Утасны дугаар:99078141